

MERIT ТӨСЛИЙН МЭДЭЭ

2019 оны 7-р сар | Сэтгүүл №4

Төрийн албан хаагчийн 154 албан тушаалын жишиг тодорхойлолт боловсруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлээ

5, 6-р сар

MERIT төслийн хүрээнд хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн Канад улсын Техникийн зөвлөхүүд болон үндэсний зөвлөхүүд Дундговь, Дорнод аймаг, сумдын ЗДТГ-ын албан хаагчидтай хамтран ажиллаж, ажлын байрны дүн шинжилгээ хийн, бусад аймгуудад түгээн хэрэгжүүлэх боломжтой 154 албан тушаалын жишиг тодорхойлолтыг богино хугацаанд боловсрууллаа.


Төслийн зөвлөхүүд нь зорилтот хугацаанаас эрт буюу 6 сарын 15-ны дотор хоёр аймаг, нэг сумын Засаг даргын тамгын газрын бүх ажилчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн ажлын байрны тодорхойлолтуудыг 6-р сарын төгсгөлд дуусгаж хүргүүлээ. ТАЗ нь эдгээр жишиг албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх үйл явцын хүрээнд үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.



Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын Жендерийн талаар баримтлах бодлогыг танилцууллаа

6-р сарын 17-8 (УУХҮЯ), 6-р сарын 26 (АМГТГ)

MERIT төсөл Жендерийн үндэсний хороо, УУХҮЯ болон АМГТГ-тай хамтран УУХҮЯ, АМГТГ-ын албан хаагчид, эрдэс баялгийн салбарын төрийн өмчит компаниудын төлөөллийг хамарсан хоёр өдрийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар 2019 оны 5 дугаар сард батлагдсан “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлого /2019-2026/”-ыг танилцуулж, салбарын албан хаагчдын жендерийн эрх тэгш байдлын талаарх мэдээллийг хүргэлээ.



УУХҮЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Ахлах мэргэжилтэн Т.Чимэгсанаа Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг танилцуулж байгаа нь, 2019 оны 6-р сарын 17




“Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-ын Сургаач багш А.Анударь Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдад жендерийн сургалт явуулав. 2019 оны 6-р сарын 26

Байгаль орчны хяналтыг сайжруулах нь

6-р сарын 12

MERIT төсөл Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар(МХЕГ)-тай хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг 2019 оны 06 сарын 12-ны өдөр байгууллаа.

Хамтын ажиллагааны хүрээнд Ашигт малтмал болон газрын тос олборлох үйл ажиллагаанд байнгын хяналт, шалгалт, үнэлгээ хийдэг улсын байцаагч, мөн удирдах ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд хамтран ажиллаж, Монгол Улсын 21 аймагт хэрэглэх, түгээн дэлгэрүүлэх сургалтын гарын авлага боловсруулах юм. Түүнчлэн байгаль орчны хяналтын чиглэлээр ажиллах төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.



MERIT төсөл МХЕГ-тай байгаль орчны хяналтыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгууллаа. 2019 оны 6-р сарын 12

Жендерийн мэдрэмжтэй манлайллыг дэмжих цуврал сургалт

5-р сарын 16

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэйл Карнеги Трэйнинг Институт болон Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд төрийн бус байгууллагатай хамтран "Манлайлах урлаг ба жендерийн мэдрэмж" сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсрууллаа.

2019 оны 5-р сараас 12-р сар хүртэл хэрэгжих тус хөтөлбөр нь байгаль орчин, аялал жуулчлалын салбарын удирдах албан тушаалтан болон албан хаагчдын манлайллын ур чадварыг бэхжүүлэх замаар удирдах чадварыг нэмэгдүүлэн, ажлын байрны чанарыг сайжруулж, бүтээлч, ая тухтай, жендерийн мэдрэмжтэй ажлын байрыг бий болгон иргэн төвтэй төрийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд чиглэсэн юм.



MERIT төсөл болон БОАЖЯ "Манлайлах урлаг ба жендерийн мэдрэмж" сэдэвт сургалтын хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллахаар тогтлоо. 2019 оны 5-р сарын 16

Төв аймаг уул уурхайн нээлттэй цахим сантай боллоо

6-р сарын 20

MERIT төслийн Техникийн зөвлөх Кармен Гагنون Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, орон нутгийн уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг нэг дор агуулсан нээлттэй цахим санг хөгжүүлэн, хөгжүүлэлтийн талаар заавар зөвлөмж өгч ажиллав. Тус цахим сангийн нээлтийн арга хэмжээ 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн Зуунмод хотод болов.

Мэдээллийн нээлттэй цахим сан хөгжүүлснээр байгалийн нөөцийн салбарт уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв, бодит мэдээллийг нэгдсэн эх сурвалжаар түгээх боломжийг бүрдүүлж байна.



Орон нутгийн Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд шагнууллаа

6-р сарын 7

Жендерийн үндэсний хорооноос төсөл хэрэгждэг Дорнод, Сүхбаатар аймгийн жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Алтанцэцэг болон Н.Бямбадорж нарыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай ажилласан тул өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Энэ нь MERIT төслийн хүрээнд хэрэгжиж буй жендерийн сургалт, зөвлөгөөний үр өгөөжийн нэг тод жишээ хэмээн үзэж байна.



ЖҮХ-нээс орон нутгийн Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг идэвх санаачилгатай ажилласныг нь үнэлж шагнав. 2019 оны 6-р сарын 7

Манлайлал ба өөрчлөлтийг удирдах нь

4-р сарын 27, 5-р сарын 24

Техникийн зөвлөх Чак Конлоны хүний нөөцийн чиглэлээрх арвин туршлага, өгөөмөр зан чанар, нээлттэй байдал нь MERIT төслийн ажилчид, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Түүний MERIT төсөлд гүйцэтгэсэн анхны томилолт нь Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн захиралтай манлайлал, өөрчлөлтийн удирдлагын талаар мэдлэг, туршлагаа хуваалцах явдал байв. Тэрээр манлайлал, өөрчлөлтийн менежмент, жендерийн мэдрэмж, залгамж халаа бэлдэх асуудлаар тус хүрээлэнгийн удирдлага, болон жендерийн клубийн гишүүдтэй ярилцаж, байгууллагын удирдлагууд жендерийн мэдрэмжтэй, манлайллын ур чадварыг сайтар эзэмшсэн байх шаардлагатайг онцлов.



MERIT төслийн Техникийн зөвлөх Чак Конлон Газарзүй, геоэкологийн хүрээлэнд “Өөрчлөлтийн менежмент” сэдэвт сургалт орж байгаа нь, 2019 оны 5-р сарын 17

Үр дүнд суурилсан менежментийг нэвтрүүлэх тухай сургалт зохион байгууллаа

5-р сарын 4-нөөс 6-р сарын 1

Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор MERIT төслийн Техникийн зөвлөх Грант Куртис Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс болон тус аймгийн 13 сумын төрийн албан хаагчдын төлөөлөлд “Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт шинжилгээ ба үнэлгээний уялдаа холбоо” сэдэвт бүсчилсэн сургалтыг 2019 оны 5-р сарын 14-24-ний хооронд зохион байгууллаа.

Түүнчлэн үр дүнд суурилсан менежментийн онол, практикийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор тус сургалтаар олж авсан мэдлэг, туршлагын талаараа Удирдлагын Академид танилцуулж, дараагийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцав.



MERIT төслийн Техникийн зөвлөх Грант Куртис Сүхбаатар аймагт “Үр дүнд суурилсан удирдлага” сэдэвт сургалт орлоо. 2019 оны 5-р сарын 13

Эрдэс баялгийн салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо ба тэдний дуу хоолой

5-р сарын 3

Эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог дэмжих зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам “Эрдэс Баялаг-Эмэгтэйчүүд” Үндэсний хоёрдугаар чуулганыг 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. MERIT төслийн зүгээс Дэйл Карнеги Трэйнинг Институттэй хамтран тус чуулганы салбар хуралдааны зуу гаруй оролцогчдод “Амжилтад хөтлөх ур чадвар” сургалт явууллаа.



Байгаль орчин ба жендэр

6-р сарын 13-14

“Хүрээлэн буй орчны шинжлэх ухаан ба технологи” олон улсын бага хурлыг Улаанбаатар хотноо 6 дугаар сарын 13-наас 14-ний өдрүүдэд Газар Зүй, Геоэкологийн Хүрээлэнгээс зохион байгууллаа. Олон улсаас хүрэлцэн ирсэн оролцогчид цаг уурын өөрчлөлтийн үр дагаврыг шийдвэрлэх шинэлэг шийдлүүдийн талаар авч хэлэлцсэн байна.

MERIT төслийн захирал Женнифер Адамс “Нөхөн сэргээлт ба хяналтын технологи” сэдэвт хэлэлцүүлгийг удирдаж, төслийн жендерийн урт хугацааны зөвлөх Миша Гофорт “Байгаль орчин ба жендерийн хоорондын хамаарлын асуудал”-ын талаар танилцууллаа.

Шинэ өглөөг шинэ санаагаар угтъя

5-р сарын 30, 6-р сарын 27

MERIT төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулахад хувь нэмрээ оруулах үүднээс MERIT төслийн Захирал хатагтай Женнифер Адамсын санаачилгаар “ШИНЭ ӨГЛӨӨ, ШИНЭ САНАА” VIP өглөөний цай, нетворкинг арга хэмжээг сар тутам зохион байгуулж байна. Уг арга хэмжээнд зочин илтгэгчид сонирхолтой сэдвээр яриа өрнүүлж, хүрэлцэн ирсэн зочид хэрэгтэй мэдээлэл авах, ажил мэргэжлийн танилын хүрээгээ тэлэх боломжийг бүрдүүлсэн юм.



MERIT төслийн урт хугацааны Техникийн зөвлөх Миша Гофорт “Хүрээлэн буй орчны шинжлэх ухаан ба технологи” олон улсын II бага хурлын үеэр илтгэл тавьж байгаа нь, 2019 оны 6-р сарын 13



MERIT төслийн Техникийн зөвлөх Рэймонд Жервайс Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн захирал Г.Номинтой нөхөрсөг яриа өрнүүлж байгаа нь, 2019 оны 5-р сарын 30



MERIT төслийн захирал Женнифер Адамс “Нөхөн сэргээлт ба хяналтын технологи” сэдэвт хэлэлцүүлгийг удирдав. 2019 оны 6-р сарын 13



“Шинэ өглөө, Шинэ санаа” VIP өглөөний цай, нетворкинг арга хэмжээний үеэр. 2019 оны 5-р сарын 30

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ



Монгол Улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нейшнл Таймс Ньюс Тауэр,
3-р давхар



info@merit.mn



www.merit.mn



+976 7016-5000



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada

MERIT төсөл нь Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр болон Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (WUSC) хоорондын түншлэлээр хэрэгжиж байна.